

**"ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2020 оны 04 дүгээр сарын
22-ны өдөр

№ ХЭХ 03/01

Улаанбаатар
хот

**"Жуулчин Дюти фрий" ХК-ийн 2020 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын
тэмдэглэл.**

2020 оны 04 сарын 22-ны өдөр 10:00 минут, Лхагва гараг, Хан-Уул дүүргийн 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Таван Богд Группийн төв байрны, 2,5 дугаар давхрын хурлын танхимд хуралдав.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Сайн байцгаана уу. Хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн амар амгаланг эрье Ингээд хурлын дэгийг та бүхэнд танилцуулъя.

Хурлын дэгийг танилцуулав.

Одоо хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу хурлын ирц бүртгэлийн талаар тооллогын комиссын дарга Т.Солонго танилцуулна.

Тооллогын комиссын дарга Т.Солонго: Сайн байцгаана уу. "Жуулчин Дюти Фрий" ХК-ийн ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн танилцуулъя.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит энэ хуралд 5 хувьцаа эзэмшигч биеэр оролцож, нийт саналын эрх бүхий нийт хувьцааны 73,20 хувь болж байгааг хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигч нар болон хурлын даргад мэдээлсүгэй. Ингэснээр хурлыг хүчин төгөлдөрт тооцож хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг үргэлжлүүлэхэд ирц хүрсэн байна.

Хурлын ирцийн тогтоолыг танилцуулав.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Хурлын ирц хүчин төгөлдөр болсон байна. Тооллогын комиссоос тогтоол гарсантай та бүхэн танилцлаа. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар ТУЗ-ийн гишүүн Ч.Ванчин-Эрдэнийг томилсон боловч Хурлын дарга орон нутагт томилолттой байгаа тул хурлыг Гүйцэтгэх захирал Ё.Ганбат даргалуулахаар ТУЗ-ийн дарга шийдсэн байна.

Хурлын дэгийн дагуу компанийн үйл ажиллагааг танилцуулаад хурлаа эхэлье.

Хурлын дарга Ё.Ганбат: Сайн байцгаана уу та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. 2019 оны үйл ажиллагааны тайланг танилцуулъя. Асууж тодруулах зүйл байвал шууд шууд асуугаад явах боломжтой.

Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах /Гүйцэтгэх захирал Е.Ганбат/ танилцуулав.

Компанийн эрхэм зорилго бол зах зээлд чанарын шаардлага хангасан өндөр чанартай үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэж салбартаа манлайлах гэсэн зорилготой. МУ-ын хэмжээнд ойролцоогоор 14 татваргүй барааны дэлгүүр ажилладаг. Энэ дэлгүүрүүдээс гол 8 нь онгоцны буудалд ажилладаг. Улирал улирлаар бараа татан авалтыг судалдаг. Бараа татан авалтаар 2020 онд 1-р явж байгаа. Манай компани 3 дэлгүүртэй. Чингис хаан ОУНБ-д нэг салбар нээж одоогоор 3 салбартайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Хөшигтийн хөндийд шинээр буудал баригдсан тэр дотор шинээр дэлгүүр нээх ажиллагаа МУ 49 хувь Япон улс нь 51 хувийг нь эзэмшээд Японы тад менежментийг нь хариуцаад ажиллаж байгаа юм байна лээ.

За ингээд цааш нь үргэлжлүүлээд тайлангаа танилцуулъя.

2016 онд “Таван Богд Трейд” ХХК нь Газар сүлжмэл ХК-ийн 67 хувийн хувьцааг буюу хяналтын багцыг худалдан авч компанийн оноосон нэрийг Жуулчин Дютри Фрий ХК болгон өөрчилсөн бөгөөд мөн компанийн бүтэц, дотоод зохион байгуулалтыг өөрчлөн үйл ажиллагааг амжилттай явуулж байна аа.

Тус компанийн ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн хараат гишүүд “Таван Богд Трейд” ХХК-ийн захирал Ц.Баатарсайхан, Д.Хулан, Ц.Оргилболд, Ц.Оюунцэцэг, Ц.Цэцэнхүү, Ч.Ванчин-Эрдэнэ гэсэн 6 гишүүнтэй байна. Хараат бус гишүүд Я.Пүрэв, Д.Байгальмаа, Ж.Мягмарсүрэн нар, Гүйцэтгэх захирал Е.Ганбат би өөрөө, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ байна. ТУЗ-ийн гишүүдэд өөрчлөлт орсон зүйл байхгүй байна.

1-р салбар Төмөр замын дэлгүүрийн татваргүй барааны дэлгүүр нь вокзалын 5 дугаар давхарт байрладаг, гаалийн хяналтын доор үйл ажиллагаа явуулдаг.

Төмөр замдаа бол дэлгүүр нэг складтай үйл ажиллагаа явуулдаг. Оны эхнээс гаалийн байцаагч камераар хянаж байгаа учраас борлуулалт тааруу, бууралттай байна.

2-р салбар Алтанбулаг шалган нэвтрүүлэх төвийн 1-р давхарт байрладаг тэнд байрлах талбай бол 46,7 м2 талбайтай үүнээс 2 складтай. Гол орлого олдог сизон нь 6-10 сар. ОХУ гарч, орж байгаа иргэдэд үйлчилж байна.

Нисэх салбар бол хамгийн том салбар бөгөөд олон нэр төрлийн барааны сонголттой дэлгүүр юм. Хувьцаа эзэмшигч та нар мөн гадагшаа нисэхдээ өөрсдийн дэлгүүрээр орж харсан байх гэж найдаж байна. Та бүхнийг бас өөрсдийн дэлгүүрээр үйлчлүүлээрэй гэж хүсэж байна.

Дэлгүүрийн бараа татан авалт бол хамгийн сүүлийнх нь 2020 оны 02 сард татан авсан. Үүнээс хойш дэлхий нийтэд гарсан Корона вирус гарснаас шалтгаалаад 3 сарын 11-ний өдрөөс УОК шийдвэр гарч 6-р тогтоолоор 3 сарын 31-нийг дуустал төмөр зам нисэх буудлын үйл ажиллагааг зогсоосон байхад ОХУ 5 сарын 1 өдрийг хүртэл хилээрээ хүн нэвтрүүлэхгүй байх шийдвэр гаргасан. Мөн энэ хугацаанд 4.30 хүртэл агаарын зам, төмөр замын үйл ажиллагааг УОК сунган зогсоосон тул манай компанийн бүх үйл ажиллагаа зогссон байна. Ямар нэгэн орлогогүй байна. Улс орон ийм хүнд байгааг харгалзан үзэж нийт ажилтнууддаа сул зогсолт зарлан нөхөн олговор олгож байна.

Шинэ нисэх онгоцны буудлын татваргүй барааны дэлгүүрийн тендер сонгон шалгаруулалтыг өнгөрсөн оны 11 дүгээр сард зарласан.

Дээрх сонгон шалгаруулалтад манай компани оролцсон, боловч биднийг 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдөр дуудаж уулзаад сонгон шалгаруулалттай холбоотой тайлбарыг авсан. Гэтэл 2 дугаар сарын 19-ний өдөр биднийг тус сонгон шалгаруулалтад тэнцээгүй гэсэн хариуг цахим хаягаар ирүүлсэн.

Манай компани дээрх шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа бөгөөд ШӨХТГ, Сангийн яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт гомдол гаргасан. Мөн Төв аймгийн захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гарган захиргааны хэрэг үүсэх шатандаа байна.

Учир нь шинэ нисэх буудлыг бид төлөвлөхдөө 3 дэлгүүрийн нийт орлогын 60 хувийг дангаар хийнэ гэж төлөвлөсөн боловч бид энэ салбар дээр их анхаарал хандуулж хөөцөлдөж байна. Засгийн газраас бас хуучин нисэхийг давхар ашиглана гэдэг яригдсан юм байна лээ. Тэгэхээр хуулийн нисэхийн салбараа ажиллуулаад явна гэж бодож байна.

За ингээд санхүүгийн тайланг компанийн ерөнхий нягтлан бодогч Энхгэрэл танилцуулна.

“Жуулчин Дютри Фрий” ХК-ийн ерөнхий нягтлан бодогч Г.Энхгэрэл:

Компанийн цэвэр борлуулалт 3,6 тэрбум өмнөх оныхоос 36% буурсан, барааны борлуулалтын өртөг 2,04 тэрбум төгрөг өмнөх оныхоос 38% буурсан үзүүлэлттэй байна. Өнгөрсөн онд 1,3 тэрбумын цэвэр ашигтай ажиллаж байсан бол 2019 онд Тайлант хугацааны нийт 676,383,000 төгрөгийн цэвэр ашигтай буюу цэвэр ашгийн 51% бууралттай ажилласан байна. Төлөвлөгөө бол 88%-тай биелсэн ийм үзүүлэлттэй 19 онд ажилласан байна.

2019 оны санхүүгийн тайланг Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан жагсаалтад бүртгэлтэй “Сүлд Аудит” ХХК-тай гэрээ байгуулан 2019 оны 12-р сарын 31-ны байдлаар санхүүгийн тайланд Хараат бус аудиторын дүгнэлт гаргуулсан болно. Дүгнэлтэд 2019 оны 12-р сарын 31-ний санхүүгийн тайлан, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан,

эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн бодлогуудад аудит хийлгэсэн. Ямар нэгэн зөрчилгүй үнэн зөв гэсэн хөндлөнгийн аудитын дүгнэлт гарсан.

Та бүхэн санхүүгийн тайлантай танилцаж болно.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Та бүхнээс өнгөрсөн оны буюу 2019 оны санхүүгийн тайлантай холбоотой асууж тодруулах зүйл байна уу.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Хувьцаа эзэмшигч нараас 2019 оны санхүүгийн тайлантай холбоотой асууж тодруулах зүйл байхгүй бол дараагийн хэлэлцэх асуудлаа хэлэлцье. Ерөнхий нягтлан бодогч Г.Энхгэрэл Компанийн 2020 оны санхүүгийн төлөвлөгөө, төсвийг танилцуулна.

Ерөнхий нягтлан бодогч Г.Энхгэрэл: Энэ оны төлөвлөгөө 1-р улиралд бол 1,2 тэрбум байсан бол 574 саяын гүйцэтгэлтэй буюу дэлгүүрийн үйл ажиллагаа COVID 19 холбоотой зогссон тул борлуулалт мөн адил зогссон байна. 1-р улиралд буюу 2020 онд одоогийн байдлаар 574 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал маань ногдол ашиг тараах эсэх тухай ТУЗ-ын шийдвэрийг танилцуулах.

Компанийн ТУЗ нь 2020 оны 02-р сарын 18-ны өдөр хуралдаж ногдол ашиг тараах эсэх тухай тогтоол гарсан. Дээрх тогтоолоор 2019 оны цэвэр ашгаас хувьцаа эзэмшигч нарт ногдол ашиг тараахгүй байхаар шийдвэрлэсэн байна. Ногдол ашиг тараахгүй байх шалтгаан нь шинэ нисэх онгоцны буудлын салбар нээх болон Алтанбулаг боомтын салбарыг шилжүүлэх зардлыг тооцоолон ногдол ашиг тараахгүй байхаар шийдвэрлэсэн байна. Ногдол ашиг тараах эсэх тогтоолтой холбоотой хувьцаа эзэмшигч нараас асууж тодруулах зүйл байна уу.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё. Компанийн санхүүгийн болон үйл ажиллагаанд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулна.

ТУЗ-ийн дүгнэлтийг уншиж танилцуулав.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё. Компанийн 2020 оны компанийн санхүүгийн төсөв, төлөвлөгөөг танилцуулна уу хэмээн ерөнхий нягтлан бодогч Э.Энхгэрэлийг урьж байна.

Ерөнхий нягтлан бодогч Г.Энхгэрэл: Манайх бол 2020 оны төсвийг бол өндөр гаргасан боловч COVID-19 холбоотой буурсан байгаа. Төмөр зам салбар 1,4 тэрбум төгрөг, Алтанбулаг салбар 828 сая төгрөгийн, Нисэх салбар 600 сая төгрөгийн борлуулалт хийнэ гэсэн төлөвлөгөөтэй явж байна. Маркетингийн зардал маань 718 сая, Ерөнхий удирдлагын

зардал 459 сая төгрөг, тайлант хугацааны цэвэр ашиг 88 сая төгрөгийн төлөвлөгөөтэй байна.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: 2020 оны санхүүгийн төлөвлөгөө, төсвөөс асууж тодруулах зүйл байна уу? хувьцаа эзэмшигч нараас.

Байхгүй гэв.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Хурлын дэгийн дагуу хэлэлцэх асуудлыг хэлэлцэж дууслаа. Хувьцаа эзэмшигч нараас компанийн үйл ажиллагаатай холбоотой болон өнөөдрийн хурлаар хэлэлцсэн асуудлаас асууж тодруулах зүйл байна уу?

Хувьцаа эзэмшигч “Би Ди Сек ҮЦК” ХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Онон: Нэг зүйл асууя. 2019 болон 2020 оны компанийн онцлог үйл явдлын талаар мэдээлэл өгнө үү?

Хурлын дарга Ё.Ганбат: 2-р сард манайх бараагаа татсан. Бас нэг чухал асуудал бол бид 3 дэлгүүрийнхээ тусгай зөвшөөрлийн хугацааг 3 жилээр сунгасан. Энэ бол маш чухал ажил байгаа юм. 19, 20 он бол их хүндхэн тусаж байна. Тэглээ гээд бид хойшоо суулгүй компанийн ашигтай ажиллуулахын төлөө хувьцаа эзэмшигч нарт ногдол ашиг тараахын төлөө ажиллаж болно гэдгийг та бүхэнд хэлмээр байна.

Хувьцаа эзэмшигч “Радар Фанд” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Баянмөнх: Хөшигтийн хөндийн сонгон шалгаруулалтын нийт дүн гараагүй байгаа юм байна тийм үү?

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Сонгон шалгаруулалтад нийт 8 оролцогч оролцсон байгаа. Урьдчилсан байдлаар 2 оролцогчийг сонгон шалгаруулсан юм байна лээ. Сонгон шалгараагүй газрууд гомдол гаргаад явж байгаа. Тэр асуудлууд нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцдаа байна. Эцсийн дүн гараагүй гэж харж байна.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Хурлын дэгийн дагуу хэлэлцсэн асуудлын хүрээнд 2 асуудлаар санал хураалт явуулна. 1-р санал хураалт ТУЗ-ийн санхүүгийн тайланд хийсэн дүгнэлтийг батлах тухай санал хураалт, 2-р санал хураалт нь Компанийн 2020 оны санхүүгийн төлөвлөгөө төсвийг батлах санал хураалт явагдана.

Саналын хуудас болон санал хураалттай холбоотой асууж тодруулах зүйл байвал нээлттэй шүү.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Тооллогын комиссоос 2 саналын дүнгээ нэгтгэн та бүхэнд танилцуулахад бэлэн болсон байна.

Тооллогын комиссын дарга Т.Солонго: Нийт өнөөдрийн хуралд 5 хувьцаа эзэмшигч оролцсоноос 100 хувийн саналаар ТУЗ-ийн 2019 санхүүгийн тайланд хийсэн дүгнэлтийг батлахаар шийдвэрлэсэн байна. Саналын 2-р хуудас буюу компанийн 2020 оны санхүүгийн төлөвлөгөө, зардлын төсвийг батлах саналын хуудсыг 100% зөвшөөрч батлахаар шийдвэрлэсэн байна.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ:

1. 2019 оны санхүүгийн төлөвлөгөө, зардлын төсвийг батлах
2. ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай тогтоолын төслүүдийг батлахаар 100 хувийн санал өгсний танилцуулав.

Хурлаар хэлэлцэх асуудлын хүрээнд оруулсан 2 асуудлаар хэлэлцсэн асуудлыг 100 хувь дэмжигдсэн учраас тогтоолын төслийг батлахаар шийдвэрлэсэн тул тогтоолыг төслийг танилцуулан баталлаа.

Ингээд өнөөдрийн хурал өндөрлөж байна хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа. Хурлыг хааж үг хэлнэ үү хэмээн хурлын дарга Ё.Ганбатыг урьж байна.

Хурлын дарга Ё.Ганбат: “Жуулчин Дютри Фри” ХК-ийн 2020 оны ХЭ хуралд хүрэлцэн ирж оролцсон та бүхэнд баярлалаа. Онцгой нөхцөл байдлаас шалтгаалан бидний шууд хийчихдэг ажил маань хийх боломжгүй хязгаарлагдмал байна. Тийм учраас ийм хүнд нөхцөл болсон ч компанийн зүгээс хууль дүрэм журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаа хийе, тайлангаа танилцуулъя гэж зориг та бүхний оролцоотой амжилттай хурлаа хийж дуусаж байна. Ингээд та бүхний ажилд амжилт хүсэн энэ хориг маань хурдан нээгдээсэй гэж ерөөл дэвшүүлье ээ.

Хурлын дарга:



Ё.Ганбат

Тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ

2020 оны 04 сарын 22-ны өдрийн 11 цаг 05 минутад дуусав.